

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 03 сарын 06 -ны өдөр  
2023 он 03 сар 01.

№ 2023/17

Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК /РД:6021646/-ийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ган-Очир (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас Рэнцэндоржийн Баасанбазар /РД:ЧЕ79101811/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) (цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

### Нэг. Нийтлэг заалт

1.1 Энэхүү гэрээгээр ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн даалгаврын дагуу, компанийн ажилтнуудын мэдлэгийн шалгалтын программ хийх ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн Захиалагчийн өмчлөлд шилжүүлэх, ажлын гүйцэтгэлийн талаар Захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3 Программын батлагаат хугацаа гэрээ хаасан өдрөөс 6 сар байна.

1.4 Захиалагч нь Гэрээнд заасан ажлын даалгавар (шаардлага)-г гэрээнд хавсаргана.

### Хоёр. Гэрээний хугацаа


2.1. Энэхүү Гэрээнд хоёр тал гарын үсэг зурж, албажсан өдрөөс 30 хоногийн дотор дуусгаж хүлээлгэж өгнө.

2.2. Гэрээ хаасан өдрөөс хойш 10 хоногт багтаан программ суулгах, тохируулах болон сургалт хийнэ

2.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

### Гурав. Ажил үйлчилгээний төлбөр

3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын үйлчилгээний төлбөр нийт 5,000,000 (Таван сая ) төгрөг байна. (Үүнд НӨАТ орсон болно). Гэрээ үйлчлэх хугацаанд гэрээний үз тогтвортой байна.



- 3.2. Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэвэл зохих нийт ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэж Захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгч тайлагнах бөгөөд Захиалагч ажлыг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор ажлын хөлсийг Ажил гүйцэтгэгч С.Баасанбазарын Худалдаа хөгжлийн банкны 468002894 тоот дансанд шилжүүлнэ

#### Дөрөв.Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1.Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 4.2.Ажлыг актаар хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 4.3.Гэрээт ажлыг заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 4.4.Хийгдсэн програмыг ашиглах талаар үнэ төлбөргүй сургалт, зааварчилгаа авах эрхтэй.
- 4.5.Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.
- 4.6.Программын баталгаат хугацаанд доголдол илэрсэн тохиолдолд ажил гүйцэтгэгчийн зардааар уг доголдлыг арилгүулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр Ажил гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 4.7.Программ суулгах серверийг бэлдэх үүрэгтэй.
- 4.7.1. Техникийн шаардлага. /бага үзүүлэлт

CPU: I7 10 үе

RAM: 16Gb

Brand: Dell

Monitor

Keyboard

Mouse

#### Тав.Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1.Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2.Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 5.3.Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.4.Дараахь тохиолдолд Захиалагчид нээн даруй мэдэгдэх үүрэгтэй:
- 5.4.1. Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дунд муугаар нөлөөлөхөөр байвал;
- 5.4.2. Ажлын чанар, үр дунд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.
- 5.5. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.
- 5.6. Захиалагчид өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх үүрэгтэй.
- 5.7. Ажлын үр дүн доголдолыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.



- 5.8. Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.
- 5.9. Ажил үйлчилгээний даалгаварын талаархи аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.
- 5.10. Ажил гүйцэтгэгч нь хавсралтанд тодорхойлсон ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.11. Захиалагч тал нэмэлт шаардлага тодорхойлж өгвөл талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр 7.3 дээр заасаны дагуу ажлыг нэмэлтээр хийж гүйцэтгэх эрхтэй.

### **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1. Талууд энэхүү гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алданги төлнө.
- 6.2. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл ҮНДЭСНИЙ БА ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ АРБИТРААР эцэслэн шийдвэрлүүлэх бөгөөд арбитрын ажиллагаанд тус арбитрын маргаан хянан шийдвэрлэх журмыг баримтална.


### **Долоо. Бусад заалт**

- 7.1. Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.
- 7.2. Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 7.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
- 7.4. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон асуудлаар 2 тал хууль, тогтоомжид заасан үндэслэлээр харилцан тохиролцож болох ба гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

**Найм. Талууд**

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:**

ИРГЭН




/Р.БААСАНБАЗАР/

УБ ХОТ, БАЯНЗУРХ ДҮҮРЭГ,  
АЛТАЙ ХОТХОН, 14-113 ТООТ  
УТАС: 99043152



/ М.МОНХӨӨ/

ЗАХИРГАА ГҮДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



/ Б.ГАН-ОЧИР/

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ



/ О.УДВАЛ /

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТАН



/ Г.САРУУЛ /



СУРГАЛТ, СУДЛАГААНЫ МЭРГЭЖИЛТЭН

*Н.ПАГМАА/*

УБ ХОТ БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 8-Р ХОРОО,

УС-15-1-1 ТООТ

УТАС: 99015032, 98071123

